



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн  
Үйлдвэрлэлийн технологийн сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Хувцасны дизайн**

Индекс: **D021201**

Шинжээчийн баг:

|                    |                                                                                                                          |
|--------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ахлагч: Б.Гантулга | /Их Засаг олон улсын их сургуулийн харьяа Дүрслэх урлаг, дизайн технологийн дээд сургуулийн захирал, доктор/             |
| Гишүүд: Г.Одпүрэв  | /Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Дүрслэх урлаг, технологийн сургуулийн дизайн, зураг зүйн тэнхимийн багш, доктор/ |
| Д.Тунгалаг         | /”Денимон” хязгаарлагдмал хариуцлагатай компаний ерөнхий захирал/                                                        |

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

1. МУ-Монгол улс
2. БНХАУ-Бүгд найрамдах хятад ард улс
3. БНСУ-Бүгд найрамдах солонгос улс
4. ХБНГУ- Холбооны бүгд найрамдах герман улс
5. ӨМӨЗО-Өвөр монголын өөртөө засах орон
6. ШУТИС- Шинжлэх ухаан технологийн их сургууль
7. ҮТС- Үйлдвэрлэлийн технологийн сургууль
8. БСШУЯ- Боловсрол соёл шинжлэх ухааны яам
9. МДХ- Монголын дизайнеруудын холбоо
10. АХБ-Азийн хөгжлийн банк
11. ХАА-Хөдөө аж ахуй
12. ШУТТНС- Шинжлэх ухаан технологийн төв номын сан
13. ЭЕШ-Элсэлтийн ерөнхий шалгалт
14. ЕБС- Ерөнхий боловсролын сургууль
15. UNIMIS- University management information system- Их сургуулийн удирдлагын мэдээллийн систем
16. ХААНӨСД- хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

|                                                  |                                                                                                                                                                          |                                                                                            |
|--------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|
| <b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>            | Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн<br>Үйлдвэрлэлийн Технологийн Сургууль<br><br>Mongolian University of Science and Technology,<br>School of Industrial Technology |                                                                                            |
| <b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b> | Хувцасны дизайн<br><br>Fashion Design                                                                                                                                    |                                                                                            |
| <b>Индекс</b>                                    | D021201                                                                                                                                                                  |                                                                                            |
| <b>Шинжээчид</b>                                 | 1. Б.Гантулга, ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС-ийн захирал, доктор<br>2. Г.Одпүрэв, МУБИС-ийн ДУТС-ийн ДЗЗТ-ийн багш, доктор<br>3. Д.Тунгалаг, Денимон ХХК-ийн ерөнхий захирал  |                                                                                            |
| <b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>                     | Н.Түмэнжаргал                                                                                                                                                            |                                                                                            |
| <b>Төлөвлөгөө</b>                                | <b>Он сар өдөр</b>                                                                                                                                                       | <b>Хийгдсэн байх ажлууд</b><br>/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу                  |
|                                                  | 2020.12.22<br>/цахимаар/                                                                                                                                                 | Оюутнуудтай уулзах<br>Ажил олгогчидтой уулзах<br>Төгсөгчидтэй уулзах<br>Багш нартай уулзах |
|                                                  | 2021.01.22                                                                                                                                                               | Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах                        |
|                                                  |                                                                                                                                                                          | Сургууль, номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцах                       |
|                                                  | Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах                                                                              |                                                                                            |
|                                                  | Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.                                                                                      |                                                                                            |

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

---

ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологи, Дизайны сургуулийн Хувцас судлалын салбарын үндэс нь 1986 онд тавигдаж хувцасны загвар зохион бүтээгч болон хувцасны технологич мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн ба 2000 онд “Хувцасны дизайн” мэргэжлийн ангийг Монгол улсдаа анхлан нээж дээд боловсролтой дизайнер, зохион бүтээгч инженер, технологичдыг бэлтгэх их үйлсэд хувь нэмрээ оруулсаар иржээ. Бакалаврын сургалтын төлөвлөгөөг:

1. Хувцасны дизайн D549903 (2003/06/27)
2. Хувцасны дизайн D543600 (2007/05/03)
3. Хувцасны дизайн D021201 (2014/07/02)
4. Хувцасны дизайн D021201 (2016/06/27) шинэчлэн баталсан.

“Хувцасны дизайн” бакалаврын хөтөлбөрөөр 4 жил суралцаад, 1.5-2.5 жилд Хувцасны дизайн, Нэхмэлийн дизайнаар мэрэгшиж магистр зэрэгтэй төгсөнө.

2006 оноос тус сургуульд Солонгосын КОИСА байгууллагын тусламжтайгаар “Дизайны мэдээллийн төв”-ийг байгуулан ажиллаж эхэлсэн нь хувцасны мэргэжлээр суралцаж буй оюутнуудад мэдээлэл олж авах боломжийг олгож эхэлсэн.

“Хувцасны дизайн” хөтөлбөрөөр төгсөгчид эзэмшсэн мэргэжлээрээ бүх төрлийн (зөөлөн оёдол, сүлжмэл, үслэг, савхи) хувцас үйлдвэрлэх жижиг, дунд, улсын, хувийн салон, үйлдвэрүүдэд хувцасны дизайнер, зохион бүтээгч, чанарын хяналтын мэргэжилтнээр ажиллахаас гадна холбогдох эрдэм шинжилгээний байгууллагад эрдэм шинжилгээний ажилтан, худалдааны байгууллагын бэлэн хувцасны загвар сонголтын мэргэжилтэн, мерчиндайзер, кино, телевиз, театрт хувцасны зураач, сэтгүүл хэвлэлийн газарт дизайнер, шүүмжлэгч, хувцасны зөвлөх - стилист, их, дээд сургууль, МСҮТ, дунд сургуулиудад мэргэжлийн багшаар ажиллаж байна.

Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн сургуулийн Дизайны салбар нь оюутны бүтээлч сэтгэлгээ, үйл ажиллагааг дээшлүүлэхэд байнга анхаарч ирсэн бөгөөд “Урлахуйн ертөнц”, “Торгон зам”, “Шилдэг даашинзны уралдаан” зэрэг мэргэжил сурталчлах уралдаан, наадмыг 2010 оноос амжилттайгаар зохион явуулж эхэлсэн бөгөөд одоо жил бүр оюутан сурагчдын хүсэн хүлээдэг, авъяас чадвараараа өрсөлддөг бүтээлч наадам болоод байна. МДХ-оос жил бүр зохион байгуулдаг “Хаврын гоёл–Дизайн сургалт” тэмцээн наадмын “Хувцас загварын уралдаан”, “Эрдэм шинжилгээний хурал”-д 2001-2017 онуудад тогтмол амжилттай оролцож ирсэн нь мэргэжлийн багш нар, оюутнуудын бүтээлч хамтын ажиллагааны илрэл юм. 2007-2013 онуудад БНСУ-ын Хувцасны дизайны холбооны үзэсгэлэн, 2019 онд ӨМӨЗО-ны уралдаанд багш оюутны бүтээлүүдээр оролцож шагналт байранд шалгарч байсан нь тухайн салбарын бахархам амжилт билээ.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- ШУТИС-ийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө 2015 бодлогын баримт бичиг
- Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, ШУТИС-ийн ректорын 2014/04/14 өдрийн А/64 тоот тушаал
- Хувцас дизайн бакалаврын сургалтын хөтөлбөрийг баталсан ректорын тушаал 2014/04

##### Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

##### Шаардлага:

- Багш нарын төлөөлөл гарган гадаадын их дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан судалгааг чанартай хийх

##### Онцлог зүйл/Туршлага:

- Дизайны тэнхимийн эрхлэгч Ц.Батсайханы санаачлагаар долоо хоногт нэг удаа хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах туршлага солилцох семинар зохион байгуулдаг нь онцлог сайн туршлага хэмээн үзэж байна. Энэ үйл ажиллагааны тухай хурлын бүрэн тэмдэглэлийн үзэж танилцсан болно.

##### Анхаарах асуудал:

- Дотоодын нэг, олон улсын дөрвөн сургуультай харьцуулсан судалгааны ажил хийсэн, хөтөлбөрийн шинэчлэлд тусгасан хэмээсэн ч тухайн ажлын талаар ямар нэг нотлох баримт танилцуулаагүй, нотлогдоогүй болно.
- PDCA судалгааны ажлын арга зүйн дараалал зөрчилтэй, мөн түүнчлэн тухайн судалгааны ажлыг тодорхой оюутны үйл ажиллагааг судлан явуулаагүй, энгийн төсөөлөл дээр тулгуулан бичсэн, мөн судалгааны ажил явуулсан баримт нотолгоо үгүй байна.

### **Зөвлөмж:**

- PDCA судалгааны ажлын арга зүйн дараалалд зөрчил гарсан байгааг анхаарах, сонгогдсон судалгааны объектыг ажиглах
- Хуучин ба шинэ хөтөлбөрийн зорилтыг харьцуулан дүгнэх
- Шинэ хөтөлбөрөөр 2014-2018 онд суралцахад ямар үр дүн гарсныг тодорхой харуулах
- Хөтөлбөрийн шинэчлэлд гадаадын их дээд сургуулиас Парисын дизайн арт коллежийг сонгон авч судалсан нь сайшаалтай, тухайн сургууль дэлхийн хувцас загварын өнгийн тодорхойлж буй загвар зохион бүтээгч нарыг бэлтгэн гаргадаг. Харин өөрийн үнэлгээний тайланд тусгасан харьцуулсан судалгаа харагдахгүй байна. Тиймээс хэлний зохих мэдлэгтэй багш нараар тодорхой хугацаатай хөтөлбөрийн харьцуулсан судалгааг хийлгэх.

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургуулийн стратеги төлөвлөгөө 2015 бодлогын бичиг баримт, гарын авлага, хоёрдугаар бүлгийн 2.1, 2.2 дахь хэсэгт сургуулийн зорилго, алсын харааг тодорхойлсон байдал
- ШУТИС-ийн бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийн хөтөлбөр бодлогын бичиг баримтын эмхтгэлийн 2.2 д заасан заалт
- ШУТИС -2030 стратеги төлөвлөгөө, ректорын 2020 оны 01 сарын 10-ны өдрийн 01 тоот тушаал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС-ийн Хувцасны дизайн хөтөлбөрийн ажил олгогч ба сүүлийн таван жилийн хугацаанд бэлтгэгдэн гарсан төгсөгчидтэй хийсэн уулзалтын үеэр манай улсын зах зээлд уг мэргэжил хэрэгцээтэй бөгөөд тус сургуулийн төгсөгч нар зонхилж байна.
- Тус хөтөлбөрийн нийт төгсөгчдөөс 14 төрлийн асуулга бүхий судалгаа хийсэн үр дүн эерэг гарсан нь тухайн мэргэжлийн зорилгын биелэлт хангалттайг гэрчилж байна.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС-ийн ҮТС-ийн хөтөлбөрийн дэд хороо хичээлийн жилийн хугацаанд дотоод журмын 2.3-д заасны дагуу 9 удаа хуралдаж, 2018 оны 09 сарын 30, 2019 оны 05 сарын 09-ний өдрийн хооронд хөтөлбөрийн төлөвлөлт хэрэгжилтийн талаар хийсэн хурлын бүрэн тэмдэглэл
- Хувцасны дизайн хөтөлбөрөөр суралцагчдад олгох мэдэг чадвар, ур чадварын хоорондын уялдааг 1-4 курсээр харуулсан сургалтын төлөвлөгөө

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн хичээл хоорондын залгамж холбоо, агуулгын хувьд босоо ба хөндлөн чиглэлд холбогдохоос гадна агуулга түүн дээр нэмэгдээд даалгаврын хөндлөн холболт нь оюутны эзэмшиж буй мэдлэгийг практик хэрэглээнд нэвтрүүлэх илүү онцлог талтай байна.
- Хичээл хоорондын уялдааг харуулсан хөтөлбөрийн модыг хийж зураглан харуулсан байна.

#### **Зөвлөмж:**

- Инженерийн сургуулийн хөтөлбөрийн арга зүйд тохируулан хийгдсэн CDIO загвар орчин үеийн дүрслэх урлаг ба дизайны хөтөлбөрийн онцлогт тохирч буй эсэх, гадаадын ижил мэргэжлийн сургуультай харилцаа тогтоох, хөтөлбөрөө хэрхэн шинэчлэн сайжруулах талаар дахин боловсруулж ажиллах

### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС-ийн хөтөлбөрүүдэд CDIO загварыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай ректорын 2015 оны 02 сарын 06 А/26 тоот тушаал
- ШУТИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороонд хүргүүлсэн санал 2016 оны 01 сарын 26



## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага

- Монгол улсад инженерийн боловсролын CDIO хөтөлбөрийг анхлан амжилттай хэрэгжүүлсэн.

### Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангахад 3D ба CAD-ийн чиглэлийн хичээлийн зохист харьцаа хэт бага, дизайны салбар өөрийн гэсэн компьютерийн лаборатори байхгүй, нэг компьютерт оногдох оюутны тоо олон байна.

### Зөвлөмж:

- Орчин үеийн хувцас дизайны 3D чиглэлийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх, оюутанд хүртээмжтэй байдлаар шийдэх.

## 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан, суралцахуйн үр дүнгийн матриц, удирдлага мэдээллийн систем дэх хичээл сонголтын байдал зэргээс харахад хичээлийн агуулгын давхардал байхгүй
- Үйлдвэрлэлийн дадлага хийлгэх тухай захирлын тушаалууд /он тус бүрээр/
- Дадлагын удирдамжууд /он тус бүрээр/
- Оюутны дадлага хийдэг хамтын ажиллагаа бүхий байгууллага, гэрээнүүд /Говь хувьцаат компанитай байгуулсан 01/137 тоот гэрээ, Дархан минж компанитай байгуулсан 18/275 тоот гэрээ, ЭМ ВИ ЭМ ЖИ ХХК тай байгуулсан 084 тоот гэрээ/
- Сургалтын хөтөлбөр ба арга зүйг сайжруулах чиглэлээр жил бүр зохион байгуулдаг CDIO-ийн сургалтад 2016 оны 04 сарын 01-ээс 2020 оны 01 сарын 16-ны хооронд сургалтад хамрагдсан 10 багшийн үнэмлэх

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн багш нарын ихэнх нь CDIO сургалтад хамрагдсан, хичээлийн хөтөлбөрийн ба заах арга зүйд CDIO-г бүрэн нэвтрүүлсэн нь онцлог байна.
- Хичээл хоорондын уялдаа холбоог тогтоохдоо цөм хичээлийг ялган, түүнтэй холбоотой хичээлүүдийг холбон багц үүсгэдэг. Тухайн сургалтыг Төсөлд суурилсан сургалт хэмээн нэрлэж, энэ нь мэргэжлийн хичээлээр олж авсан мэдлэгийг бататгах, ур чадварыг дээшлүүлэх, бие даан асуудлыг шийдэх сайн талыг оюутанд олгож байна.

### Зөвлөмж:

- Багш нар цагийн хуваарь гарган төв сургуульд видео хичээл бичүүлэхэд хэдэн сарын дараалал үүсч байдаг. Тиймээс салбар сургууль ба тэнхимийн нөөц бололцооны хүрээнд видео хичээл бэлтгэж болно.
- PDF материалаар хичээлийг зохион байгуулахад шаардлага хангахгүй учир видео хичээлд сайн анхаарах хэрэгтэй.

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС-ийн удирдлага мэдээллийн систем оюутны мэдлэг чадварыг үнэлэх 10, 20, 20, 20, 30 үнэлгээний дүрэм
- ШУТИС-ийн тестийн систем (<http://www.testcenter.edu.mn/>)
- Өөөрийн үнэлгээний тайлангийн 49-57 дугаар хуудсанд буй сургалтын арга зүйг харуулсан хүснэгт, загвар
- Must.edu.mn буюу сургалтын удирдлага мэдээллийн системд буй оюутны цагийн ачаалал ба сэтгэл ханамжийн судалгаа /улирал бүрээр/

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар оюутны мэдлэг чадварыг үнэлэхдээ 10, 20, 20, 20, 30 задаргаа үнэлгээг баримталдаг нь хөтөлбөрийн нарийн хэсэг бүрд дүгнэн ахиц гаргах онцлог талтай байна.
- Оюутны суралцах идэвх, мэргэжлийг сурталчлах зорилгоор Урлахуй ертөнц, Хаврын гоёл зэрэг сургуулийн болон улсын хэмжээний уралдаан наадмыг тогтмол зохион байгуулдаг нь сайн туршлага.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутан мэргэжлийн дагуу хөгжихөд бие даалтын тусгай цаг ба анги танхимын хүрэлцээт байдал муу байна.

#### **Зөвлөмж:**

- Гадаадын их дээд сургуультай хамтын ажиллагааг эрчимжүүлэх, оюутан ба багш солилцооны олон улсын хөтөлбөрт хамрагдах
- Бүс нутгийн болоод олон улсын оюутны тэмцээн уралдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тэнхимийн хамт олны үйл ажиллагааг сургуулийн зүгээс сайн дэмжих, эрдэмжилтийн талаар, мөн материаллаг хэрэглэл, орчин нөхцөлийг анхаарах

#### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл
- Хөтөлбөрийн талаар багш, төгсөгч, оюутнуудтай хийсэн уулзалт тэмдэглэлүүд
- Багш нартай уулзаж хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- ШУТИС-ийн багш оюутнуудад зориулсан шүд, дотор, нөхөн сэргээх, эмчилгээ оношилгооны кабинетуудтай зургаан эмч, нэг сувилагчтай эрүүл мэндийн төв ажиллаж байгаа нь тав тухтай, эрүүл сурч ажиллахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.
- Сүүлийн үед ХХААХҮЯ-ны дэмжлэгтэй АХБ-ны санхүүжилтээр сургалтын тоног төхөөрөмжүүдээ шинэчлэн сайжруулсан нь оюутнуудад орчин үеийн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж дээр сурч дадлагажих сайн төсөл болсон байна.

#### Анхаарах асуудал:

- Сургуулийн байрны чанар, өнгө үзэмж муу. Санхүүжилт муугаас анги танхимын ширээ сандал солих, засварлах бололцоо тааруу.

#### Зөвлөмж:

- Дизайны чиглэлээр сурч байгаа оюутнууд болон энэ чиглэлээр сургалт явуулж байгаа багш нарт зориулсан бие даан ажиллах, бүтээл гаргах орчин нөхцөлөөр хангасан зай талбай, өрөө тасалгаа шинээр байгуулах.

#### 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл
- Хөтөлбөрийн талаар багш, төгсөгчид, оюутнуудтай хийсэн уулзалт тэмдэглэлүүд
- Багш нартай уулзаж хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ярилцсан тэмдэглэл

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Цар тахлаас үүдэлтэй онлайн сургалтад зориулан багш нар лабораторит орох сургалтуудаа видео хэлбэрээр бэлдэн оюутнууд гэртээ даган хийх маягаар зохицуулж байгаа нь сургалтын үйл явцыг тасалдуулалгүй явуулж байгаа сайн жишээ байна.
- Улаанбаатар хотод байрлах оёдлын үйлдвэрүүдтэй хамтран ажиллаж оюутнуудаа дадлага хийлгэж байгаа нь суралцагчдад онол практик хосолсон цогц мэдлэг олж авахад давуу тал үүсгэж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Өөрсдийн давуу талаа ашиглан бусад сургууль, гадаадын сургуулиудтай хамтран ажиллах оюутан солилцох үйл ажиллагааг эхлүүлэх
- Багш нарыг чадваржуулж сүүлийн үеийн тоног төхөөрөмж, шинэ бүтээлүүдтэй танилцах, олон улсын хувцас үйлдвэрлэлтэй холбоотой үзэсгэлэн, сургалтуудад хамруулах
- Сургалтын хэрэгцээнд зориулан ашиглаж байгаа компьютерүүдийн хүрэлцээ муу 2 оюутны дунд 1 компьютер ногдож байна. Мөн сургалтад ашиглаж байгаа компьютеруудын ихэнх нь хүчин чадал доогуур буюу 78% нь Acer i3 үзүүлэлттэй байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болно гэж үзэж байна.

#### **Шаардлага:**

- YTC-ийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд хангалттай санхүүжилт гаргах шаардлагатай.

#### **Зөвлөмж:**

- Үйлдвэрлэгчидтэй хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж харилцан ашигтай хамтран ажиллах. Жишээ нь: Оюутны бүтээлүүд болох шинэ загвар, зохион бүтээлт, шинэ санаануудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг зөвшөөрөх, үйлдвэрлэгчдэд шаардлагатай байгаа мэргэжлийн зөвлөгөө сургалтууд явуулах, хариуд нь тэднээс сургалтын үйл ажиллагаанд ашиглах боломжтой давуу, утас, цаас болон бусад хэрэглэгдэхүүнийг авах боломжтой гэж үзэж байна.
- Эсгүүрийн CAD программыг зөвхөн магистр оюутнуудад биш бакалаврын түвшний сургалтад ашиглах. БНХАУ-д өргөн ашиглагддаг, одоогоор Монголын зарим оёдлын үйлдвэрүүдэд амжилттай ашиглаж байгаа хямд бөгөөд ашиглахад хялбар BOK CAD программыг сургалтанд нэвтрүүлэх. Ингэснээр төгсөгчид хөдөлмөрийн зах зээл дээр илүү үнэ цэнэтэй мэргэжилтэн болох шалтгаануудын нэг болно гэж үзэж байна.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл
- Хөтөлбөрийн талаар багш, төгсөгч, оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэлүүд
- Сууль дээр ажиллах үед төв сургуулийн номын сангийн талаар мэдээлэл өгөх зорилготой видео бичлэг

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- e-liberaгу буюу цахим ном ашиглаж эхэлсэн нь цаг үетэйгээ нийцсэн сайн туршлага болжээ.
- “Burda” сэтгүүлийг тогтмол захиалан ашигладаг нь багш оюутнууд сүүлийн үеийн олон улсын хувцас загварын чиг хандлагатай танилцах боломж олгож байна.

#### **Зөвлөмж:**

- Санхүүгийн боломж бололцооны улмаас ном, сурах бичгийн фондыг шинэчлэх, нэмэгдүүлэх боломж тааруу ч гэсэн энэ тал дээр анхаарал хандуулж, боловсролын байгууллагуудад зориулагдсан олон улсын төсөл хөтөлбөрт хандаж санхүүжилт босгох боломжийг судлах.
- Багш нар өөрсдөө бас олон улсын түвшний мэдээлэл дээр тулгуурлан хичээл сургалтаа зохион байгуулах, суралцагчдаа дэмжиж туслах, бие даасан судалгааны ажлуудыг илүү хийлгэхийг зөвлөж байна.

#### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмууд
- Шинэчилсэн хөтөлбөрийн боловсруулалт, сайжруулалтыг сургалтын хэлтэс, хөтөлбөрийн ерөнхий хороо хэлэлцдэг тухай нотлох баримтууд
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт хугацаанд 10 жилийн төлөвлөгөөтэй, богино хугацаанд жил бүр тэнхимийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргаж, биелэлтийн тайланг улирал бүрээр гаргаж ажилласан баримтууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- “ШУТИС-ийн хөгжлийн стратегийн замын зураглал 2012-2021”, “ШУТИС-ийн 2020-2030 он мастер төлөвлөгөө” зэрэг урт хугацааны төлөвлөгөөнүүдийг хамт олноороо хэлэлцүүлж, тодорхойлон хэрэгжүүлэх үе шатуудыг нарийвчлан гарган ажиллаж байна. Богино хугацааны төлөвлөгөөг гаргахдаа жил болгон багш нарын ажлын төлөвлөгөөнд үндэслэдэг. Хичээл сургалт, оюутны оролцоо, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг ШУТИС-аас батлан гаргасан профессор, багш нарын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журамд нийцүүлэн дүгнэж гаргадаг байна.
- Хөтөлбөрийн удирдлага нь хөтөлбөрт ирсэн санал гомдол шийдвэрлэдэг, мэргэжлийн болон ажил олгогчдын зүгээс тавьдаг шаардлагыг хангасан хөтөлбөрийг боловсруулахад анхаарч тухай бүрт нь эргэх холбоотойгоор сайжруулан ажилладаг.
- Хөтөлбөрийн нэгжийн шийдвэр гаргалт, хэрэгжилтэд багш, оюутны оролцоог нэн тэргүүнд тавьж ажиллахыг зорьж, шаардлагатай дүрэм, журмуудыг албажуулдаг.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудаас гарсан санал асуулгын дүнгийн дагуу хийсэн ажлыг тодорхой тусгаж, эргэж тайлагнадаг байх.

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Мэргэжлийн чиглэлийн гэрээ, хэлцэл хийхэд оролцсон материал, гэрээт ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын судалгаа
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх мэдээлэл, SWOT, TOWS шинжилгээ

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар үйлдвэр, аж ахуй, сургалтын 9 байгууллагатай бүтээгдэхүүний чанар хийц, шинэ загварт оруулах, стандарт, техникийн бичиг баримтуудыг боловсруулах гэх мэтээр гэрээ байгуулан хамтран ажиллах, оюутнуудыг өргөнөөр хамруулан оролцуулж, мэргэжлийн хичээлтэй холбоотойгоор дадлагажуулдаг байна. Мөн гэрээт ажлын орлогын 10% нь сургуулийн хөгжил, дэвшилд нэмэр хандив болгон хичээл практикын зардал болон лабораторийн тоног, төхөөрөмжийн шинэчлэлд дэмжлэг болдог байна. “Хувцас судлалын төв”-ийн орчин үеийн шинэ тоног төхөөрөмжүүд (CAD, SHIMA, 3D body scanner) дээр ажиллах ажлын байрыг бэлтгэж, суурилуулж хичээл сургалтад ашиглаж байна.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч нь Монголын Дизайнеруудын Холбоо, Оёдлын Үйлдвэрүүдийн Нэгдсэн Холбоо гэх мэт мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллагуудтай олон талаар хамтран ажилладаг байна.

### Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын гадаад, дотоодтой хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болон гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх, улмаар нийгэмд үзүүлэх үйлчилгээг тодорхой түвшинд ахиулах
- Оюутан, багш солилцооны хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, тайланг хэлэлцдэг байх
- Хамтын ажиллагаатай орнуудад солилцоогоор явах багш, суралцагчдын тоог нэмэгдүүлэх
- Шилдэг төгсөгч болон тухайн салбарт үр бүтээлтэй ажиллаж буй төгсөгчдийн судалгааг хийж сурталчилгааны сан бүрдүүлэх
- Хөтөлбөрийн удирдлага нь мэргэжлийн болон ажил олгогчдын зүгээс тавьдаг шаардлагыг хангахын тулд “Хувцас судлалын төв”-ийн орчин үеийн шинэ тоног төхөөрөмжүүд дээр төгсөгчдөд эргэх холбоо үүсгэх зорилгоор цагийн хуваарьт оруулан байнгын ажиллагаатай “start up” бий болгох

### 4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдээллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл

## Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвийг тухайн жилийн инфляци, суралцагчдын тоо, багш ажилтны тоо, зардлын үзүүлэлтүүдийг зүйл бүрээр тооцон ШУТИС-ийн хэмжээнд нэгтгэн холбогдох төрийн байгууллагаар баталгаажуулдаг.
- Үндсэн үйл ажиллагааны орлого нь бакалавр, магистр, докторын сургалтын төлбөр, түр сургалтын төлбөрийн орлогоос бүрддэг байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан; нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо; сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ; хөтөлбөрт хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд оруулсан төсөв, төсвийн зарцуулалт; төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайланг хүснэгтлэн гаргасан байна. Үүнд: Нийт зардлын 52.7 %-ийг сургалтын үйл ажиллагааны зардалд, 36.1 %-ийг шууд бус зардалд, 9.3 %-ийг төсөл, гэрээт ажлын зардалд, 0.6 хувийг оюутны үйлчилгээний зардалд, 1.4 хувийг хөрөнгө оруулалтын зардалд тус тус зарцуулдаг байна.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн багш нар сургалтын төлбөрөөс орох орлогын зохих хувийг мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, сургалтын орчин, лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр захиран зарцуулах эрхтэй байдаг боловч хөтөлбөрүүдийн орлого хангалтгүй байгаа шалтгаанаар энэ нь тэр бүр хэрэгждэггүй.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн зардлын төсвийн зарцуулалтын тайлан тухайн оныг өмнөх онуудтай харьцуулахад багассан байгаа нь учир дутагдалтай.

### **Шаардлага:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн зардлын төсвийн зарцуулалтаа нарийвчлан гаргаж төлөвлөх шаардлагатай.
- Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зориулах зарцуулалтыг нэмэгдүүлэх

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээг дахин боловсруулж бодитой тооцоолол гарган сургалтын төлбөрийн бодит хэмжээг тогтоох, төсөвлөдөг болох
- Сургалтын хөтөлбөрт зарцуулагддаг зардлын төсвийг тодорхой гаргах

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Оюутан элсүүлэх дүрэм журам
- Өөрийн үнэлгээний тайлан



- Монголын Дизайнеруудын Холбооноос зохион байгуулдаг “Гоёл-2019”, “Хаврын гоёл-дизайн сургалт” наадмуудад идэвхтэй оролцож, багш, оюутнуудын ур чадварыг сурталчлан төгсөгчдийг ажлын байраар хангадаг байдал
- Тандан судалгаа, дүгнэлт холбогдох материал, хийсэн ажил, арга хэмжээгээ тайлан баримтаар нотлосон нотолгоо

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Монголын Дизайнеруудын Холбооноос зохион байгуулдаг “Гоёл-2019” наадамд хөтөлбөрийн багш Б.Гэрэлмаа нь үндэсний хувцасны төрлөөр “Эрдэнэ эрхшээгч” коллекци, мөн Б.Дулмаа, Б.Гэрэлмаа нар өдөр тутмын хувцасны төрлөөр “Нүүдэл” коллекциор 16 хувцас урлаж Тусгай байрын шагнал хүртсэн байна.
- Монгол Улсын Засгийн газраас “Үйлдвэржилт 21:100”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” зэрэг үндэсний хөтөлбөрүүдийг баримтлан өнөөг хүртэл хэрэгжүүлж байгааг тайландаа дурдсан. Жишээ нь: АХБ-ны ХААНӨСД төслийн хүрээнд “Дэлхийд итгэмжлэгдсэн хариуцлагатай үйлдвэрлэл-оёдлын үйлдвэрийн өөрийн үнэлгээ гүйцэтгэх” гарын авлага ном, “Гоёо” ХХК-ий бүтээгдэхүүнд эрүүл мэндэд ээлтэй, биед эвтэй, удаан эдэлгээ, өнгө хэлбэрээ алддаггүй гэх мэтээр чанарын шаардлага хангасан тул олон улсын чанарын стандартын “ОЕКО TEX-100 standart” гэрчилгээ авсан. АХБ-ны санхүүжилтээр 6 аймаг, Улаанбаатар хотын 10 сургуулийн 9000 хүүхдийг судалгаанд хамруулж Монгол хүүхдийн биеийн хэмжээний стандартыг батлуулсан.
- Улсын болон сургууль, салбарын хүрээнд үзэсгэлэн, уралдаан, хурал, зөвлөгөөн жил бүр зохион байгуулан уламжлалт монгол агуулгыг орчин үеийн хэрэглээнд нэвтрүүлэх зорилготой “Торгон зам”, “Урлахуй ертөнц”, “Алтан хулгана” наадмыг явуулж сурталчилдаг.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр сурталчлах, чанартай элсэгч элсүүлэхэд зориулан Маркетингийн төлөвлөгөөтэй болох.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургалтын үйл ажиллагаандаа E-Cloud Unimis системийг нэвтрүүлж хэвшсэн байдал
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн, тогтмол хангалттай бүрэн ажиллагаатай байдал
- Удирдлагын мэдээллийн системийг “CLOUD UNIVERSITY” системд шилжүүлсэн нь олон нийтэд илүү хүртээмжтэй мэдээллийн системийн дэвшил

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургууль нь динамик веб сайттай, эндээс багш нарын талаарх мэдээлэл, судалгааны чиглэл, шинээр гарсан ном, багш оюутны шинэ бүтээл, гарын авлагын талаарх мэдээллийг авч болдог.
- Кредит системийн хүрээнд удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэн ажиллаж байгаа нь хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал, ашиглалтыг нийтэд хүртээмжтэй байгаа давуу талтай байна.
- Сургуулийн facebook хаягийг тогтмол ажиллуулдаг.

### **Зөвлөмж:**

- Элсэгчдийн ур чадварын ялгаатай байдлыг арилгах сургалт явуулж байх.

### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургууль дээр ажиллаж өөрийн үнэлгээний тайланд тусгасан мэдэллүүдийг баталгаажуулсан тэмдэглэл
- Хөтөлбөрийн талаар багш, төгсөгч, оюутнуудтай хийсэн уулзалт, тэмдэглэлүүд
- Сургуулийн цахим хуудас дээрх мэдээлэл

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутнууд хүсэл сонирхол авьяасаараа орж ирсэн учир сурах хүсэл тэмүүлэл өндөр байдаг.
- Сүүлийн үед мэргэжлээ сурталчлах шинэ арга болгож багш нараараа мэргэжил болон хичээлийнх нь талаар видео танилцуулга хийлгэж байгаа нь шинээр элсэх хүсэлтэй оюутнуудад хүссэн мэдээллээ авах боломж олгож байна.
- Төрөөс авч хэрэгжүүлж байгаа дотоодын хувцас үйлдвэрлэлийг дэмжих бодлого, шинээр үүсэн гарч ирж байгаа хувцасны брэндүүдийн нэр хүнд өсөж байгаа нь энэ хөтөлбөрт сурах хүсэлтэй оюутны тоонд эерэгээр нөлөөлж байгаа.

**Зөвлөмж:**

- Олон нийтийн сүлжээгээр “Хувцасны дизайн” хөтөлбөрийн талаар болон энэ мэргэжлийн ач холбогдлын талаар илүү сурталчлах. Төгсөгчдийн 90 гаруй хувь нь ажлын байраар хангагддаг, мөн энэ мэргэжил нь хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт ихтэй мэргэжил гэдэг давуу талаа сурталчилгаандаа оруулах.
- Багш оюутнууд олон улсын мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцуулах, энэ талаар идэвх санаачлагатай ажиллах.

**5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн талаар багш нартай хийсэн дэлгэрэнгүй ярилцлагын тэмдэглэл
- Өөрийн үнэлгээний тайлан
- Өөрийн үнэлгээний тайланд болон багш нарын тайлбарыг баталгаажуулсан баримт бичгүүд
- Сургуулийн цахим хуудас дээрх мэдээлэл

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Зөвлөх багш ажиллуулдаг нь сайн туршлага гэж үзэж байна. Шинэ орчинд орж ирж байгаа оюутнуудад сургууль болон суралцах үйл явцад хурдан дасан зохицоход нь маш их давуу тал үүсгэж байгаа гэж үзэж байна. Оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд зөвлөх багшийн талаарх оюутнуудын үнэлгээ өндөр байсан нь үүнийг нотолж байна.
- Оюутнуудын дунд зохиогддог загвар, дизайны тэмцээнүүд уламжлал болон тогтсон бөгөөд эдгээр нь оюутнуудын мэдлэг чадвар, ур ухааныг сорьсон уралдаан болж чадсан.

**Зөвлөмж:**

- Оюутнууд хэт бусдаас хараат, бэлэнчлэх сэтгэлгээнд суралцахаас зайлсхийх

**5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл
- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургууль дээр хийсэн танилцах аялалын тэмдэглэл

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны клубын үйл ажиллагаа тэдэнд олон давуу талуудыг бий болгодог. Чөлөөт цагаа зөв, үр бүтээлтэй өнгөрөөхөд нь ихээхэн нөлөө үзүүлдэг.
- Сургуулиас зохион байгуулагддаг уралдаан тэмцээнүүдийн талаар оюутнууд сэтгэгдэл өндөр байдаг.
- Суралцагч төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг. Суралцагчдыг олимпиад уралдаан тэмцээнд оролцоход нь зориулж тодорхой мөнгөн дэмжлэг үзүүлдэг ба энэ тоо нь сүүлийн жилүүдэд өсөж байгаа. Сайн сурсан оюутнуудыг урамшуулах хөтөлбөртэй.

### **Зөвлөмж:**

- Ажил олгогч, хувцас үйлдвэрлэлийн компаниудтай хамтран үйлдвэрийн байран дээр мэргэжлийн ур чадварын уралдааныг зохион байгуулах. Ингэснээр ажил олгогчид хүссэн мэргэжилтнээ олж авах, оюутнууд үйлдвэрлэлтэй танилцаж, ирээдүйн ажлын байрныхаа талаар тодорхой ойлголттой болох давуу талууд үүснэ гэж харж байна.
- Энэ клубын үйл ажиллагааг илүү идэвхжүүлэх тал дээр сургуулийн зүгээс олон талаар дэмжлэг үзүүлэх.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Өөрийн үнэлгээний тайланд болон багш нарын тайлбарыг баталгаажуулсан баримт бичгүүд
- Сургуулийн цахим хуудас дээрх мэдээлэл

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

### **Илрэл нотолгоо:**

- Төгсөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэл
- Өөрийн үнэлгээний тайлан
- Өөрийн үнэлгээний тайланд болон багш нарын тайлбарыг баталгаажуулсан баримт бичгүүд
- Сургуулийн цахим хуудас дээрх мэдээлэл

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- С диплом нь амьдралын боломж, шаардлагаас болоод сургуулиа бүрэн гүйцээж чадаагүй оюутнуудад боломж олгож байна.
- Төгсөгчидтэй уулзсан уулзалтаас харахад төгсөлтийн баримт бичиг болон түүний олголтын талаар хүндрэл гардаггүй тухай дурдаж байсан. Төгсөгчид төгсөөд ажлын байранд хангалттай сайн хамрагдаж чаддаг. Энэ хөтөлбөрт суралцаж төгссөн 5 төгсөгч мэргэжлээрээ гадаадад суралцаж байна.

### Зөвлөмж:

- Шалгалтыг тухай хичээл заасан багш авч дүгнэсний дараа хөндлөнгийн багшаар заавал хянуулах хөндлөнгийн системийг бүрдүүлэх. Энэ нь оюутны эрх ашгийг хамгаалах, дүнгийн нэгдсэн жишиг тогтоох чухал үр дүнтэй гэж үзэж байна.

## 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

### Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн ректорын 2015 оны 02 сарын 05-ны өдрийн А/22 тоот багш сонгох шалгаруулалт
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангиллын судалгаа
- Өөрийн үнэлгээний тайлан

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нарын 50% нь техникийн болон урлахуйн ухааны доктор, 33,3% дэд профессор цолтой, 50% магистр зэрэгтэй байна. “Хувцасны дизайн” хөтөлбөрийн багш, оюутны харьцаа 1:14 байгаа нь их сургуульд тавигдах нийтлэг шаардлагад

бүрэн нийцэх төдийгүй багш нар оюутнуудтай тулж харьцах, сургалтын үр дүнд эерэг нөлөө үзүүлэх давуу тал болно.

- Профессор багшийн хийж гүйцэтгэсэн ажлыг дараах албан тушаалын ангилалтайгаар 3 үндсэн чиглэл (Сургалтын үйл ажиллагаа, Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, Сургууль, олон нийтийн үйлчилгээ)- ээр нийт 1000 хүртэл оноогоор үнэлдэг байна.
- Хөтөлбөрийн багш Б.Оюун-эрдэнэ, Р.Юмжирмаа нар “Топ 100 багш”-д багтсан бөгөөд сургуулийн шилдэг багшийн шалгаруулалтад байнга оролцож 2019 онд багш Б.Гэрэлмаа ШУТИС-ийн “Шилдэг бүтээлч багш”-аар шалгарсан байна.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн багш нарыг хичээлийн жилд орох ажлын цагийн ачааллыг анхаарч стандартын дагуу мөрдүүлэх.
- Олон улсын индекс бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн урамшуулал, үнэлэмжийн асуудлыг нэмэгдүүлэх.
- Багш нарын хөгжилд цагийн менежент чухал үүрэг гүйцэтгэдэг тул өөрийгөө хөгжүүлэх боломж бололцоог гаргах, ажлын ачааллын тэнцвэртэй байдлыг хангах.

#### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дээд боловсролын тухай хууль болон ШУТИС-ийн бодлогын баримт бичиг, бусад холбогдох дүрэм, журмууд
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг байдал
- Багшийн хөгжлийн төв “Сургах-Суралцахуйн” аргазүйн сургалт, семинар, уулзалт-ярилцлага явуулж, санал зөвлөмжүүдийг гарган, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулж, CDIO хөтөлбөрийн шинэчлэлийн талаар мэдээлэл өгч, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байдал
- Холбогдох талуудтай хийсэн цахим уулзалт
- Өөрийн үнэлгээний тайлан

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- ШУТИС-ийн ректорын А\238 тоот тушаалаар БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ 2015 оны 11-р сард байгуулж, бүтцийн схем гаргасан.
- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг 2016 оноос CDIO-ийн сургалтад шат дараалалтай хамруулан хөтөлбөрийн үндсэн арга зүй болгосон.
- Хөтөлбөрийн багш доктор Ц.Батсайхан НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага болох ЮНЕСКО-ийн зөвлөхөөр 2 удаа сонгогдон ажилласан.

- ҮТС болон Дизайны салбарын багшийн хөгжлийн бодлогын дагуу бүх багш нарыг хамруулсан 7 удаагийн сургалт явагдсан.

**Зөвлөмж:**

- Боловсрол судлал, заах аргагүй, сэтгэл судлалын чиглэлээр сургалтуудыг зохион байгуулж, багш нарыг хамруулах
- Бүрэлдэхүүн сургууль болон салбар дээрээ багш хөгжлийн төв байгуулж, уран бүтээлч багш нарыг өөрийгөө хөгжүүлэх, уран бүтээлд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Хувцасны дизайны хөтөлбөрийн багш нараар хувцасны дизайны онолын хичээлийн сурах бичгүүд зохион хэвлүүлж, сургалтад ашиглан нийтийн хүртээл болгох

**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- ШУТИС-ийн захиалгат төсөлд оролцож, судалгааны гэрээт ажил хийж оролцсон байдал
- Холбогдох талуудтай хийсэн цахим уулзалт
- Өөрийн үнэлгээний тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо нь: Дүрэмт болон хөдөлмөр хамгааллын хувцас загвар 100, улсын 2, байгууллагын стандарт 4, техникийн бичиг баримт 3 боловсруулж үйлдвэрт нэвтрүүлж, нийтдээ 289,3 сая төгрөгийн гэрээт ажлуудыг гүйцэтгэсэн байна.
- Хөтөлбөрийн багш нараас гадаадад монографи 1, эрдэм шинжилгээний өгүүлэл 7, бүтээл 8; дотоодод 15 өгүүлэл, 15 илтгэл тус тус хэвлүүлсэн байна.
- 2014-2019 онд гүйцэтгэсэн гэрээт болон төслийн ажлын төсөв, тайланг жагсаасан байна.

**Зөвлөмж:**

- Багшийн мэргэжил ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, модуль, мэдээллийн болон хэрэглэгдэхүүний цахим сан бий болгох
- Хувцасны зохион бүтээлт, материал, технологитой холбоотой судалгаанаас гадна хувцасны дизайн, уран сайхны шийдэлтэй холбоотой судалгааны ажлыг өргөжүүлэх, үр дүнг уран бүтээлд ашигладаг болох

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш нарын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийдэг байдал
- Багшийн өөрийн үнэлгээнд удирдлагын зүгээс хөндлөнгийн үнэлгээ хийж, сэтгэл ханамжийн судалгааг бүх түвшинд авдаг байдал
- Холбогдох талуудтай хийсэн цахим уулзалт
- Өөрийн үнэлгээний тайлан

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн үйл ажиллагааны баримт хавтасыг файл бүрдүүлэлтээр 7 төрлөөр хийдэг байна. ШУТИС-аас багшийн дэвтрээр хангаж сургалтын хуваарь, оюутны ирц үнэлгээг тэмдэглэдэг нь уламжлал болгосон байна.
- ШУТИС нь багшийн хөндлөнгийн үнэлгээг 2 хичээлийн жилийн давтамжтай гүйцэтгэдэг бөгөөд 2012-2013 оны хичээлийн жилээс эхлүүлэн “Эрдэм шинжилгээний вэб”-г хөгжүүлснээр багш бүр өөрийн оролцон гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөр, хэвлүүлсэн өгүүлэл, ном сурах бичгийн талаарх мэдээллийг бусадтай хуваалцах бүрэн боломжтой болгосон байна.
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангийн 100 онооны 15 оноо буюу Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ – 5 оноо, Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ – 5 оноог, Оюутан, суралцагчийн зүгээс багшлах үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ – 5 оноог тус тус хөндлөнгөөс үнэлдэг байна.

#### **Зөвлөмж:**

- Багш нарын үнэлгээг өөрийн, суралцагчдын, хамт олны үнэлгээ гэсэн гурван субъект хамтран оролцдог тул бодитой гарч, удирдлага хөндлөнгийн үнэлгээ хийж ажлын үр дүнг гаргадаг байх.

#### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.



### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөө
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудаас авсан судалгаа
- Чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлага

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС-ийн ректорын 2009 оны 162 тоот тушаалаар “ШУТИС-ийн Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталсан бөгөөд уг журмыг мөрддөг байна. Мөн 2017 онд ШУТИС-ийн хөтөлбөрийн хорооны журмыг шинэчлэн баталсан.
- ШУТИС-ийн хөтөлбөрийн хороо нь хөтөлбөрийн ерөнхий хороо /2014.05.06/, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо /2014.09.24/ гэсэн бүтэцтэйгээр ажилладаг ба ШУТИС-ийн хөтөлбөрийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, боловсруулах, зөвлөн туслах, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх үүрэгтэй ажилладаг байна.
- Чанарын дотоод баталгаажуулалтын явц, үечлэлийн харуулсан зураглалыг гаргасан.
- Чанарын гарын авлага, сургалтын хөтөлбөрийн шалгуур, шаардлагын биелэлтэд өөрийн үнэлгээ хийх жишиг үзүүлэлтийг гаргасан байна.
- Хөтөлбөрийн чанарын сайжруулалтад ажил олгогч, төгсөгчийн саналыг авч хөтөлбөрт шаардагдаж буй өөрчлөлт, төгсөгчдөд дутагдаж буй ур чадварт дүгнэлт хийн сайжруулах тал дээр анхаарч SWOT, TOWS шинжилгээ хийсэн байна.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн чанарын сайжруулалтад оролцогч талуудаас санал асуулга авах ажлыг тогтмол хийж тусгах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн чанарын баталгаажилтын талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх
- Хувцасны дизайны улсын стандарт байдаг бөгөөд түүнийг хэрхэн хангаж байгааг тусгаж байх

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

### **Илрэл нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Холбогдох талуудтай хийсэн цахим уулзалт

- Нотлох баримтууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Мөн төгсөгчтэй хийсэн уулзалтаас нийт төгсөгчийн 90 гаруй хувь нь ажлын байртай ч мэргэжлийн дагуу эхэндээ хийдэггүй тодорхой хугацааны дараа эрхэлдэг, 10 орчим хувь нь хувийн шалтгаанаар өөр чиглэлээр одоохондоо ажиллаж байгаа тухай ярьж байсан.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээг 2019 онд шинэчлэн төгсөгчийн мөшгөх судалгаа хийсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчидтэй хийсэн цахим уулзалтын үеэр программ хангамжийн болон гадаад хэлний бэрхшээл тулгарч байгаа талаар анхааруулсан.

#### **Зөвлөмж:**

- Төгсөгч, ажил олгочийг урьж ирүүлэн оюутанд нээлттэй хичээл, ярилцлага, танилцуулга, хэлэлцүүлэг хийлгэх.
- Төгсөгчдөө давтан сургах, эргэх холбоотой ажиллах талаар ажил зохион байгуулах. Мэргэжлийн эрэлт хэрэгцээнд гарч байгаа өөрчлөлтийг байнга судлаж хөтөлбөрийн бүтэц, агуулгыг уян хатан зохицуулах зорилгоор төгсөгчидтэй тогтоосон эргэх холбоо, сургалтад гарч байгаа шинэлэг ололтуудыг тогтмол ашиглах зохион байгуулалтын нэгжтэй болох

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь олон улсын болон дотоодын үзэсгэлэн фестиваль тэмцээнд тогтмол амжилттай оролцдог тухай өөрийн үнэлгээний тайланд хавсаргасан материал, бусад нотлох баримт
- Оюутнуудын суралцаж байх хугацаандаа оролцсон олон улсын болон дотоодын уралдаан тэмцээний амжилтууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг нь тодорхой давуу талтай. Жишээ нь: “Өлүн мэнч”, “Говь”, “Урбан жинс” гэх мэт олон оёдлын нэгдлүүдтэй

хамтран дадлага, ажлын байраар хангадаг юм байна. Мөн Шимазики Азийн сургалтын төв байгуулагдсанаар дэвшилтэт технологийг нэвтрүүлж байна.

- Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний төлөвлөлтийг PDCA загвараар боловсруулсан байна.

**Зөвлөмж:**

- Санал асуулгын судалгааны асуулгууд хэрэгжилт, хяналт, шинжилгээ, мониторингийн үнэлгээ хийх шалгуур, үзүүлэлт тогтоох эсэхийг эргэж харах.

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## ДҮГНЭЛТ

| Шалгуур        |                                                | Бүрэн хангасан (2)    | Хэсэгч лэн хангасан (1) | Хангаа гүй (0) | Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/ |
|----------------|------------------------------------------------|-----------------------|-------------------------|----------------|------------------------------------------------------------------------------|
| 1              | Хөтөлбөрийн төлөвлөлт                          | •                     |                         |                |                                                                              |
| 2              | Сургалтын үйл ажиллагаа                        | •                     |                         |                |                                                                              |
| 3              | Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | •                     |                         |                |                                                                              |
| 4              | Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт       | •                     |                         |                |                                                                              |
| 5              | Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа             | •                     |                         |                |                                                                              |
| 6              | Багшийн үйл ажиллагаа                          | •                     |                         |                |                                                                              |
| 7              | Чанарын үнэлгээ, баталгаажилт                  | •                     |                         |                |                                                                              |
| <b>Дүгнэлт</b> |                                                | <b>Бүрэн хангасан</b> |                         |                |                                                                              |

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн “Хувцасны дизайн” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... /Б.Гантулга/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Г.Одпүрэв/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Д.Тунгалаг/

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

|                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Сургуулийн нэр</b>                                      | Шинжлэх ухаан технологийн их сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| <b>Хөтөлбөрийн нэр</b>                                     | Хувцасны дизайн                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>Хөтөлбөрийн индекс</b>                                  | D021201                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| Шалгуур 1.<br>Хөтөлбөрийн төлөвлөлт                        | <ul style="list-style-type: none"> <li>Инженерийн сургуулийн хөтөлбөрийн арга зүйд тохируулан хийгдсэн CDIO загвар орчин үеийн дүрслэх урлаг ба дизайны хөтөлбөрийн онцлогт тохирч буй эсэх, гадаадын ижил мэргэжлийн сургуультай харилцаа тогтоох, хөтөлбөрөө хэрхэн шинэчлэн сайжруулах талаар дахин боловсруулж ажиллах</li> </ul>                                                                                                                                                                                                                                                             |
| Шалгуур 2.<br>Сургалтын үйл ажиллагаа                      | <ul style="list-style-type: none"> <li>Орчин үеийн хувцас дизайны 3D чиглэлийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх оюутанд хүртээмжтэй байдлаар шийдэх</li> <li>Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тэнхимийн хамт олны үйл ажиллагааг сургуулийг зүгээс сайн дэмжих, эрдэмжилтийн талаар, мөн материаллаг хэрэглэл, орчин нөхцөлийг анхаарах</li> </ul>                                                                                                                                                                                                                                                          |
| Шалгуур 3.<br>Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц | <ul style="list-style-type: none"> <li>Эсгүүрийн CAD программыг зөвхөн магистр оюутнуудад биш бакалаврын түвшний сургалтад ашиглах. БНХАУ-д өргөн ашиглагддаг, одоогоор Монголын зарим оёдлын үйлдвэрүүдэд амжилттай ашиглаж байгаа хямд бөгөөд ашиглахад хялбар BOK CAD программыг судлах, сургалтад нэвтрүүлэх</li> <li>Ном, сурах бичгийн фондыг шинэчлэх, нэмэгдүүлэх боломжийг судалж ажиллах</li> </ul>                                                                                                                                                                                     |
| Шалгуур 4.<br>Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт     | <ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудаас гарсан санал асуулгын дүнгийн дагуу хийсэн ажлыг тодорхой тусгаж, эргэж тайлагнадаг байх</li> <li>Хөтөлбөрийн удирдлага нь мэргэжлийн болон ажил олгогчдын зүгээс тавьдаг шаардлагыг хангахын тулд “Хувцас судлалын төв”-ийн орчин үеийн шинэ тоног төхөөрөмжүүд дээр төгсөгчдөд эргэх холбоо үүсгэх зорилгоор цагийн хуваарьт оруулан байнгын ажиллагаатай “start up” бий болгох</li> <li>Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зориулах зарцуулалтыг нэмэгдүүлэх</li> </ul> |
| Шалгуур 5.<br>Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ              | <ul style="list-style-type: none"> <li>Багш оюутнууд олон улсын мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцох, энэ талаар идэвх санаачлагатай ажиллах</li> <li>Ажил олгогч, хувцас үйлдвэрлэлийн компаниудтай хамтран үйлдвэрийн байран дээр мэргэжлийн ур чадварын уралдааныг зохион байгуулах. Ингэснээр ажил олгогчид хүссэн мэргэжилтнээ олж авах, оюутнууд үйлдвэрлэлтэй танилцаж, ирээдүйн ажлын байрныхаа талаар тодорхой ойлголттой болох давуу талууд үүснэ.</li> </ul>                                                                                                                           |

|                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|-----------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Шалгуур 6.<br/>Багшийн үйл<br/>ажиллагаа</p>                                               | <ul style="list-style-type: none"> <li>• Багш нарын хөгжилд цагийн менежмент чухал үүрэг гүйцэтгэдэг тул өөрийгөө хөгжүүлэх боломж бололцоог гаргах, ажлын ачааллын тэнцвэртэй байдлыг хангах</li> <li>• Бүрэлдэхүүн сургууль болон салбар дээрээ багш хөгжлийн төв байгуулж, уран бүтээлч багш нарыг өөрийгөө хөгжүүлэх уран бүтээлд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх</li> <li>• Хувцасны дизайны хөтөлбөрийн багш нараар хувцасны дизайны онолын хичээлийн сурах бичгүүд зохион хэвлүүлж, сургалтад ашиглан нийтийн хүртээл болгох</li> <li>• Хувцасны зохион бүтээлт, материал, технологитой холбоотой судалгаанаас гадна хувцасны дизайн, уран сайхны шийдэлтэй холбоотой судалгааны ажлыг өргөжүүлэх, үр дүнг уран бүтээлд ашигладаг болох</li> </ul> |
| <p>Шалгуур 7.<br/>Чанарын үнэлгээ,<br/>баталгаажилт</p>                                       | <ul style="list-style-type: none"> <li>• Төгсөгч, ажил олгогчийг урьж ирүүлэн, оюутанд нээлттэй хичээл, ярилцлага, танилцуулга, хэлэлцүүлэг хийлгэдэг байх</li> <li>• Мэргэжлийн эрэлт хэрэгцээнд гарч байгаа өөрчлөлтийг байнга судлаж хөтөлбөрийн бүтэц, агуулгыг уян хатан зохицуулах зорилгоор төгсөгчидтэй тогтоосон эргэх холбоо, сургалтад гарч байгаа шинэлэг ололтуудыг тогтмол ашиглах зохион байгуулалтын нэгжтэй болох</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <p><b>ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/</b></p> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <p>1.1. Хөтөлбөрийн<br/>хэрэгцээ,<br/>шаардлага</p>                                           | <ul style="list-style-type: none"> <li>• Хэлний зохих мэдлэгтэй багш нараар тодорхой хугацаатай хөтөлбөрийн харьцуулсан судалгааг хийлгэх</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <p>3.2. Сургалтын<br/>хэрэглэгдэхүүн</p>                                                      | <ul style="list-style-type: none"> <li>• Дизайны чиглэлээр сурч байгаа оюутнууд болон энэ чиглэлээр сургалт явуулж байгаа багш нарт зориулсан бие даан ажиллах, бүтээл гаргах орчин нөхцөлөөр хангасан зай талбай, өрөө тасалгаа шинээр байгуулах</li> <li>• Сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах</li> <li>• ҮТС-ийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд хангалттай санхүүжилт гаргах</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <p>4.3 Санхүүжилт</p>                                                                         | <ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөрийн багш нар сургалтын төлбөрөөс орох орлогын зохих хувийг мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, сургалтын орчин, лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр захиран зарцуулах эрхтэй байдаг боловч хөтөлбөрүүдийн орлого хангалтгүй байгаа шалтгааныг судлан, хэрэгжүүлэх</li> <li>• Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн зардлын төсвийн зарцуулалтаа нарийвчлан гаргаж төлөвлөх</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                          |

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

| <b>Ажил олгогч</b><br><i>(Хугацаа: 2020 оны 12 сарын 22 өдөр 10.30-11.30)</i> |              |                               |                                                                   |          |
|-------------------------------------------------------------------------------|--------------|-------------------------------|-------------------------------------------------------------------|----------|
| №                                                                             | Овог нэр     | Байгууллага                   | Албан тушаал                                                      | Утас     |
| 1                                                                             | Б.Болормаа   | “Говь” ХК                     | Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны дарга                           | 99043112 |
| 2                                                                             | М.Цолмандах  | “Цоло Мөнх” брэнд             | Захирал, дизайнер                                                 | 94097607 |
| 3                                                                             | Б.Жанна      | “Жанна” хувцас загварын урлан | Захирал, дизайнер                                                 | 90488098 |
| 4                                                                             | Б.Сувд       | “Монгол костюмс” ХХК          | Захирал                                                           | 99999917 |
| 5                                                                             | Д.Ариунхүү   | “Лугати” ХХК                  | Зөвлөх                                                            | 99905743 |
| 6                                                                             | С.Мөнхжаргал | “Michel & Amazonka” брэнд     | Захирал                                                           | 99013856 |
| <b>Төгсөгч</b><br><i>(Хугацаа: 2020 оны 12 сарын 22 өдөр 11.30-12.30 )</i>    |              |                               |                                                                   |          |
| №                                                                             | Овог нэр     | Төгссөн он                    | Байгууллага, албан тушаал                                         | Утас     |
| 1                                                                             | Н.Адъяадулам | 2015                          | “Минжээ тайлор” брэнд дизайнер                                    | 99890619 |
| 2                                                                             | Л.Буянжаргал | 2016                          | “Алунгуа” брэнд захирал, дизайнер                                 | 89941111 |
| 3                                                                             | Э.Болормаа   | 2017                          | Суралцаж байгаа                                                   | 96274454 |
| 4                                                                             | Т.Баярмаа    | 2018                          | Ахисан түвшинд суралцаж байгаа                                    | 99256221 |
| 5                                                                             | М.Алтынай    | 2018                          | “Чүнпи” ХХК захирал, дизайнер                                     | 99419918 |
| 6                                                                             | Б.Намуунаа   | 2018                          | “Денимон” ХХК стилист                                             | 99602416 |
| 7                                                                             | Ж.Удвалцэцэг | 2019                          | “Топ” сургалт үйлдвэрлэлийн төвд багш                             | 96111502 |
| 8                                                                             | Б.Мөнхчимэг  | 2019                          | “Говь” ХК мэдээллийн ажилтан                                      | 99710330 |
| 9                                                                             | А.Энхнаран   | 2020                          | “Michel & Amazonka” брэнд стилист                                 | 94041282 |
| 10                                                                            | Ц.Эрдэнэханд | 2020                          | “Эвсэг кашмер”, Кашмер холдингийн сүлжмэлийн тооцоологч, дизайнер | 96335511 |
| <b>Суралцагч</b><br><i>(Хугацаа: 2020 оны 12 сарын 22 өдөр 13.00-14.00)</i>   |              |                               |                                                                   |          |
| №                                                                             | Овог нэр     | Курс                          | Сонгосон байдал                                                   | Утас     |

|    |              |      |                                                                            |          |
|----|--------------|------|----------------------------------------------------------------------------|----------|
| 1  | Э.Оюусэцэн   | ХД-5 | 4-өөс дээш жил суралцаж байгаа                                             | 99681258 |
| 2  | Ж.Сосорбарам | ХД-4 | Хөгжлийн бэрхшээлтэй                                                       | 88454764 |
| 3  | Э.Нямцэцэг   | ХД-4 | Орон нутгийн оюутан                                                        | 89860521 |
| 4  | Н.Хулан      | ХД-4 | Оюутны байранд амьдардаг                                                   | 85218810 |
| 5  | Л.Баасандорж | ХД-4 | Эрэгтэй                                                                    | 99885611 |
| 6  | Д.Хэрлэн     | ХД-3 | Голч өндөртэй (GPA 3.59)                                                   | 89849400 |
| 7  | П.Нансалмаа  | ХД-3 | Орон нутгийн оюутан                                                        | 80706099 |
| 8  | Б.Индра      | ХД-3 | Сурахын хажуугаар мэргэжлийн чиглэлээр ажил хийдэг (Zaya Tuvshinbat брэнд) | 91243313 |
| 9  | Ц.Мөнхжаргал | ХД-2 | Орон нутгийн, 1 жилийн чөлөө аваад эргэн суралцаж байгаа                   | 90630130 |
| 10 | Д.Мөнхсайхан | ХД-2 | Голч өндөр (GPA 3.6)                                                       | 99649978 |
| 11 | Э.Ариунзаяа  | Хд-2 | Ижил мэргэжлийн сургуулиас шилжиж ирсэн                                    | 88706565 |
| 12 | О.Саруул     | ХД-1 | Улаанбаатар хотынх                                                         | 99859135 |

**Багш**

*(Хугацаа: 2020 оны 12 сарын 22 өдөр 14.00-15.00)*

| № | Овог нэр     | Салбар                                               | Албан тушаал                 | Утас     |
|---|--------------|------------------------------------------------------|------------------------------|----------|
| 1 | П.Булга      | Үйлдвэрлэлийн технологийн сургууль                   | Дэд захирал                  | 88033695 |
| 2 | Д.Түмэнболд  | Дизайны салбар                                       | Салбарын эрхлэгч             | 99081565 |
| 3 | Ц.Батсайхан  | Дизайны салбар                                       | Хөтөлбөр хариуцсан профессор | 99175564 |
| 4 | М.Баяр       | Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбар | Салбарын дэд профессор       | 8801367  |
| 5 | Д.Буяндэлгэр | Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбар | Ахлах багш                   | 99168340 |
| 6 | Р.Юмжирмаа   | Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбар | Ахлах багш                   | 99298224 |



|    |               |                                                      |                            |          |
|----|---------------|------------------------------------------------------|----------------------------|----------|
| 7  | Л.Ишдорж      | Дизайны салбар                                       | Ахлах багш                 | 88870000 |
| 8  | Б.Отгончимэг  | Дизайны салбар                                       | Ахлах багш                 | 99188898 |
| 9  | Б.Мөнхзул     | Дизайны салбар                                       | Ахлах багш                 | 88006646 |
| 10 | Б.Оюун-Эрдэнэ | Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбар | Ахлах багш                 | 88150004 |
| 11 | П.Болормаа    | Дизайны салбар                                       | Ахлах багш                 | 88063225 |
| 12 | Б.Гэрэлмаа    | Дизайны салбар                                       | Багш                       | 80188006 |
| 13 | Г.Мөнхцэцэг   | Дизайны салбар                                       | Сургалтын мастер           | 96619992 |
| 14 | Б.Дулмаа      | Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбар | Сургалтын мастер           | 96057293 |
| 15 | О.Хишигжаргал | Дизайны салбар                                       | Салбарын эрхлэгчийн туслах | 89681133 |

**ШУТИС-ийн ҮТС-ийн Хувцасны дизайн хөтөлбөрийн оролцогч талуудтай хийсэн цахим уулзалтуудын товч тэмдэглэл**

2020.12.22

Шинжээчийн багийн ахлагч Б.Гантулга  
Шинжээчийн багийн гишүүн Г.Одпүрэв  
Шинжээчийн багийн гишүүн Д.Тунгалаг

Ажил олгогчдын төлөөлөлтэй хийсэн цахим уулзалтын товч тэмдэглэл

Б.Гантулга: Энэ мэргэжлээр төгсөгчид мэргэжлийн шалгуурт хэр нийцэж байна вэ?

- Жанна: Би өөрөө ажил олгогч, бас төгсөгч. Ур чадвар мэдлэг бол гологдоогүй. Гэхдээ төгсөгчдийг задгай сэтгэх хэрэгтэй гэж бодогддог. Энэ талыг нь хөгжүүлэх хэрэгтэй. Би гадаадад магистр төгссөн, гологдоогүй. Гэхдээ төгсөгчдийг заавал нэмж сургах шаардлага гардаг.

Г.Одпүрэв: Төгсөгчдийн компьютерийн программ дээр ажиллах чадвар ямар байна вэ? CAD-ын чиглэлийн программ хөтөлбөрт тусгагдсан байна. 3D байхгүй байна.

- Энэ хичээлийн цагийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж бодож байна. Төгсөгчид компьютерт тааруу байна. Гараар зурахдаа ч тааруу юм харагдаж ажиглагдаж байна.

Б.Гантулга: Хөтөлбөрт ямар чадвар чадамжийг нэмж оруулахыг хүсэж байна вэ? Танайд хэдэн төгсөгч байна вэ? Дадлага хийж байна уу? Ур чадвар нь ямар байна?

- Болормаа (Говь ХХК): Манайд ШУТИС төгссөн 300 гаруй инженер ажиллаж байна. Төгсөгчид суурь мэдлэг сайтай ирдэг. Цааш нь хөгжүүлээд явдаг. Хувцасны дизайны гучаад төгсөгчид ажиллаж байна. Оюутнууд сарын дадлага хийдэг. Үүнийг уртасгавал

зүгээр санагддаг. Нэг улирал ч юм уу. Зохион бүтээлтийн чадвар илүү хөгжсөн байдаг. Уран сайхан талаасаа жаахан дутмаг санагддаг.

- Сувд (Монгол костюмс): Манайх олон сургуулиас төгсөгчид авдаг. Ажиллаад удалгүй магистрт явчих юм. Ур чадварын хувьд бол муугүй байдаг. Бусад сургуулиудтай харьцуулахад инженерийн талын мэдлэгтэй, сайн төгсөгчид байдаг. Үндэсний түүхээ судлах хэрэгтэй.

Д.Тунгалаг: Ямар хичээлийг нэмэх эсвэл хасах санал та бүхэнд байна вэ? Олон улсад өрсөлдөх чадвар нь ямар байна?

- Сувд: Гадаад хэлний мэдлэг чадварын хувьд үнэхээр дутагдалтай байдаг. Ялангуяа англи хэл. Үндсэн программ бол сайн.
- Жанна: Олон улсад өрсөлдөх туршлага тал дээр хэлэхэд манай оюутнууд сайн гэж хэлмээр байна. Их хурдан хөгждөг. Байнга хөгжиж байвал зүгээр. Цаашид үргэлжлүүлэн сурах нь зөв гэж бодож байна.
- Түүхэн хувцасны судалгааг хийх нь зөв. Түүхийн цагийг нэмэж, түүхээ судлах хэрэгтэй. Мөн дадлагын хугацааг уртасгах хэрэгтэй гэж бодож байна.
- Загварчлалын тал дээр сайн байна. Уран сайхны тал дээр анхаарах хэрэгтэй. Компьютерийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх хэрэгтэй.
- Болормаа: Манайх дадлага хийдэг оюутнуудыг цалинжуулдаг. Гурван сараас дээш хийвэл цалин өгнө. Манай коллекц хагас жил гаруй үргэлжилдэг учраас дадлагыг үүнтэй уялдуулан урт хугацаагаар хийвэл зүгээр, их юм сурна. Цалин авна.
- Сувд: Манайд дадлага хийх боломж байдаг ч цөөн хүн ирдэг. Унаа, хоолны мөнгө өгдөг. Цалин хөлс олгодог. Манайд оюутнууд дадлага хийх боломжтой шүү.
- Жанна: Хөрвөр чадварын хичээл орж байгаа юу? Байхгүй бол оруулаарай. Битгий хасаарай гэж сургуульд уламжилъя.

#### Төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн цахим уулзалтын товч тэмдэглэл

Б.Гантулга: Төгсөөд ажилд ороход хэр хугацаа зарцуулсан бэ? Ямар бэрхшээл тулгарч байв? Суралцах явцад хамгийн дурсамжтай зүйл юу байсан бэ? Сурах арга барилаасаа хуваалцаач.

- 2000 онд төгссөн. Говь ХХК-д ажиллаж байна. 5 сарын сүүлээр төгсөөд 6 сард дипломоо аваад анкет бөглөөд 8 сард ажилд орсон. Дизайны орон тоо байгаагүй болохоор өөр местэнд ажилд орсон. Сургуулийн клуб хамгийн дурсамжтай байсан. Удирдаж, илтгэж сурсан.

Д.Тунгалаг: Ажилд ороход ямар мэдлэг туршлага хэрэг болсон бэ? Юуг сурах хэрэгтэй байсан бэ? Олон улсад өрсөлдөх чадвараа сорьсон уу?

- Төгсөөд гарахад сургуульдаа хангалттай мэдлэг хуримтлуулж чадсан. Яг одоогоор дутагдсан зүйлгүй байна. Төгссөнөөсөө хойш тэмцээн уралдаанд одоогоор оролцоогүй байна.
- Би Денимон ХХК-д стилистээр ажилладаг. 2018 онд төгссөн. Хавар төгсөөд намар нь ажилд орж байсан. ШУТИС төгссөн гэхээр хүмүүс уриалгахан хүлээж авдаг. Ажиллаад эхлэхээр сурсан бүх зүйл хэрэг болдог. Сурч байх үедээ бол өөрийгөө их голдог байсан. Сургуульдаа клуб ахалсан нь их хэрэгтэй, зөв зүйл байсан. Өөрийгөө их хөгжүүлж чадсан гэж бодож байна. Хүмүүстэй харьцах харьцаанаас эхлээд үр дүнтэй байсан. Оюутан байхдаа гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх хэрэгтэй байсан. Дизайн, зохион бүтээлтийн шатлалтай мэдлэгтэй болсон юм шиг санагдаж байна. Стилистээр ажиллаж болох юм байна гэж бодогдсон. Стилистийн хичээл үздэг. Олон улсад өрсөлдөх бүрэн боломжтой.

Б.Гантулга: Сургалтын чанар ямар байна? Ажил олгогчдын шалгуурт хэр нийцэж байна? Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаанд оролцдог уу?

- 2018 онд төгссөн. Одоо магистрт суралцаж байна. Мэргэжлээрээ бус дижитал маркетинг чиглэлээр ажилласан. Практик талын бэрхшээл илүү тулгардаг. Клубын үйл ажиллагаа практик талын мэдлэг олгодог. Тэмцээнүүд хичээлээс гадуур мэдлэг их олгодог. Төгсөөд бүх талын мэдлэг хэрэг болсон. 2019 онд Шанхай руу текстилийн сургалтад явсан. Сургуулиас ерөнхий мэдлэгээ олж аваад цаашид өөрийгөө хөгжүүлээд явбал олон улсад өрсөлдөх бүрэн боломжтой. Хэзээ төгсөж байгаагаас ажил олох процесс янз бүр байдаг гэж бодож байна.

Б.Гантулга: Ажил мэргэжлийн сонголтод зөвлөх багш нар зөвлөгөө өгдөг үү?

- 2015 онд төгссөн. Хонхны баярын маргааш ажлын санал авсан. Ариунаасури шоунд Болормаа багшийн зөвлөснөөр орж ур чадвар их суусан. Онолын мэдлэг сайн олгодог. Практик дадлага жаахан сул байсан. Зураг, зохион бүтээлтийн хичээлүүдийг сайн сурсан. Программ хангамжийн болон гадаад хэлний бэрхшээл тулгарч байсан.
- ШУТИС төгсөгчдийн холбоо байдаг. Хувцасны дизайн хөтөлбөрийн хувьд клубын үйл ажиллагаагаар явагддаг. Групп байдаг. Ажилд зуучилах зэрэг хэрэгтэй мэдээллээ авдаг. Сургуулийн 60 жилийн ой болоход Инспирейшн клубын зүгээс найрал дууны хувцсыг хариуцаж, эсгэж оёулсан. Сайн дурын 2 ажил хийх ёстой байдаг. Нэг удаа сургуулийн бүх манеканы бүрээсийг сольсон.

Б.Гантулга: Төгсөгчдийн төлөөлөл сургуулийн ажилд оролцдог уу? Санал авдаг уу?

- 2018 оны Торгон замын зохион байгуулсан. Хурал уулзалтад урьдаг. Санал асуулга авдаг.
- 2016 онд төгссөн. Төгсөөд шууд Хөх хотод ажиллахын тулд Ур ундрах брэндэд ажиллаж байгаад явсан. Тэнд очоод өөрийн брэндтэй болох санаа төрсөн. Одоо Хөвсгөл аймагтаа хувиараа ажиллаж байна. Ажлын байранд ороход загвараа гарга, эсгэ, оё гээд биднээс бүгдийг хүсдэг.
- Би эгчтэйгээ хамтарч ажиллаж байна. Одоо төгсөнө. Хичээлүүд жил бүр улам чанаржиж байна. Төгсөгчдөө давтан сургах, эргэх холбоотой ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Г.Одпүрэв: Хөтөлбөрт программ хангамжийн хичээл бага байна. Та нараас асууя гэж бодож байсан боловч та бүхний ярианаас хариултаа авлаа.

Д.Тунгалаг: Сургалтын материаллаг баазын хүрэлцээ хангамж болон оюутны байрны хүрэлцээ ямар байдаг вэ?

- Материаллаг баазын хувьд 2018 оноос шинэчлэгдээд сайжирсан. Хуучин хүрэлцэхгүй байх тохиолдол байдаг байсан.
- Багшийн хяналтан доор ашигладаг.
- Одоо нээлттэй ашигладаг болсон. Зориулалтаар нь бид нар машин техникээ ашигладаг.

Г.Одпүрэв: Сургуулийн судалгаанд та бүхэн хамрагдсан уу?

- Бичгээр судалгаа авсан, түүнд хамрагдсан.

Б.Гантулга: Сурч байхдаа мэргэжлийн зургийн ямар программ ашигласан бэ?

- Хөх хотод ажиллаж байхдаа Монгол улсын Ариундэлгэр гэдэг мундаг хүний шавь болох боломж олдсон. Материал дээр зургаа буулгахад сурсан програмаа ашигласан, хэрэг болсон. Өөрийгөө хятад, өвөр монгол төгсөгчидтэй жишиж үзэхэд тэд биднээс тааруу санагдсан. Autocad сурсан. Дипломын ажлаа хийсэн. CAD сурсан.
- Ур чадвараа хэр хөгжүүлсэн бэ? Багш нарын зүгээс та бүхнийг хэр хөгжүүлсэн гэж бодож байна вэ?

- Би анх нэгдүгээр курсдээ интерьер дизайнер болно гээд хувцас дизайны ангид орчихлоо. Ишдорж багшийн хичээлд анх суугаад энэ мэргэжлийг сонгож, ангидаа үлдсэн. Дөрвөн жил их юм сурсан. Үзсэн бүх л хичээл хэрэг болсон.
- Дэлхийн хэмжээнд fashion illustration гээд цахим орчинд зохион байгуулдаг тэмцээн байдаг. Багш нар маань үүнийг судлаад оюутнуудаа оролцуулахад анхаарах хэрэгтэй. Б.Гантулга: Төсөл хөтөлбөр, тэтгэлэгт хамрагдаж байсан уу?
- Ажилд ороход юу чаадаг нь чухал болохоос хэн ч миний дипломыг үзээгүй, голч дүнг асуугаагүй.
- Ажлын үнэлэмж?
- Бид өөрсдөө үзэл бодлоо илэрхийлэх, ярих чадвартай байх ёстой. Хэлний мэдлэг сайтай байх хэрэгтэй. Төгссөн учраас тэмцээнд орох гэхээр хураамж өндөртэй байдаг. Тиймээс оюутан байхдаа тэмцээнд орж үзэхийг зөвлөж байна.

#### Суралцагчдын төлөөлөлтэй хийсэн цахим уулзалтын товч тэмдэглэл

Б.Гантулга: Мэргэжлийн талаарх ойлголт? Сургуулийн орчин? Багшийн ур чадвар?

- Би 3-р курсийн оюутан. Хүссэн мэргэжлээрээ суралцаж байна. Багш нар маань мэргэжлийн талаар чадварлаг. Өгсөн даалгавраа чанга шалгадаг. Хэрэгцээтэй мэргэжил гэж үзсэн учраас өөрөө сонгосон, дуртай.
- Бусдад урам зориг, хүсэл бэлэглэх мэргэжил гэж үздэг. Багш нар маань чанга. Цагийн юм цагтаа. Бидний биеэ даах чадварыг хөгжүүлдэг. Барилга байгууламжийн хувьд орчин нөхцөл жаахан хэцүү.
- Би 4-р курс. Бүх талын чадварыг зэрэг хөгжүүлдгээрээ давуу гэж боддог. Практик талаас илүү хөгжүүлж чаддаг. Олон сургуулийг судалж үзээд энэ сургуулиа сонгосон. Багш нарын мэдлэг чадвар үнэхээр сайн. Кабинетийн хүрэлцээ тийм ч сайн биш.
- Сургуулийн орчин жаахан жижиг. Хүүхэд бүр локиртой бол зүгээр санагддаг. Багш нар их нээлттэй, бидэнтэй чөлөөтэй тулж харьцдаг. Дүн гаргахдаа чанга. Би өөрөө сонгож орсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцдаг уу?
- Манай ангид хөгжлийн бэрхшээлтэй хоёр оюутан суралцдаг. Сонсголын бэрхшээлтэй. Банг нар маань тэр хүүхдүүдэд тусалж байдаг нь баярладаг. Бид нартай өрсөлдөхүйц суралцдаг.

Г.Одпүрэв: Мэргэжил сурталчлах ажилд оюутнууд хэр оролцож байна вэ?

- Инспирэйшн гээд хувцас загварын клуб байдаг. Багш, оюутнууд үйл ажиллагаагаа явуулдаг. 2, 3-р курсийн оюутнууд заавал тэмцээнд оролцох ёстой байдаг.
- Оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцож байсан уу?
- Би хоёр удаа оролцсон. Багш нар сайн тусладаг. Урлагийн түүхийн багш нарын зөвлөгөө хэрэг болдог.
- 3-р курсээс эрдэм шинжилгээний хуралд оролцож болдог. Би одоогоор оролцоогүй.
- Гадаадтай хамтарсан төсөл хэрэгжиж байдаг. Үүнтэй холбоотойгоор оюутныг шалгаруулж авсан тохиолдол байна уу?
- Сонсож байгаагүй юм байна. 2-р курсэд Францаас мэргэжилтэн ирээд лекцэнд нь суугаад сертификат авж байсан.
- Компьютерийн хүрэлцээ хэр байна вэ?
- Сургуулийн лабораторийн хүртээмж муу. Компьютер гайгүй байдаг.

Б.Гантулга: Орлоготой оюутан гэж сонссон уу?

- Сонсоогүй.
- Сургууль дээр албан байгууллагуудын цагийн ажилд зуучлах зар явдаг.

Б.Гантулга: Мэргэжлийн номны хүрэлцээ ямар байдаг вэ?

- Ном дутмаг, хүрэлцээ муу.
- Онлайн номын сан байдаг. Монгол хэл дээрх ном цөөн ч гэлээ цахимааар бол байдаг.
- Цахим хичээл ямар байна? Үр дүн?
- Тиймсээр холбогдож үзэж дуусгасан. 100% бол сураагүй. Манай мэргэжил практик ихтэй болохоор хангалттай мэдлэг авч чадахгүй байна. Хүүхэд бүр гэртээ оёдлын машингүй гэх мэтээр.
- Багш нар заавар зааварчилгааг хангалттай ойлгуулж байгаа.

Д.Тунгалаг: Дадлага үр дүнтэй байна уу

- 3-р курсэд бид нар натур зурдаг. Тэрэлжид манай сургуулийн полигон байдаг.
- Дадлага хийх газраа үр дүнтэй сонгохоос шалтгаалах байх.
- Оюутны байр ямархуу вэ?
- Оюутны байр орчин нөхцөл сайн. Байрны эрхлэгч сайн ажилладаг. Дөрвөн душтэй. Бидэнд хүрэлцээтэй, тухтай байдаг.
- Монгол номны хүртээмж ямархуу байна?
- Ихэнх мэргэжлийн ном орос, англи хэлээр байдаг.
- Мэргэжлийн мэдээллийг зөвхөн номноос биш гадаадын сайтуудаас ч бас авдаг.

Г.Одпүрэв: 4-р курсэд тусгай мэргэжлийн англи хэлний хичээлийн чанар ямар байна?

- Багш багшаас хамаараад өөр өөр номноос ордог. Миний сонгосон багш график дизайн талдаа илүү мэдлэгтэй багш байсан.
- Сургуулиас бие даан суралцах хуваарь гаргаж өгсөн үү?
- Байдаг. Сургуулиас гаргаж өгдөг. Мэргэжлийн хичээлүүд дээр байдаг.
- 1-р курс. Бие даалтын хичээлийн цагтай давхцаад байдаг. Дээшээ курс болохоор давхацдаггүй.
- Нэг группт хэт олон оюутан байх тохиолдол бий юу?
- Анх нэгдүгээр курсэд багтахгүй байх тохиолдол байсан. Тэр үед групп болгож хувааж байсан.

Д.Тунгалаг: Тусгай зориулалтын машин дээр ажиллаж үзсэн үү?

- Үзсэн. Клубээс бүтээл хийсэн. Бусад оюутнууд хангалттай ажиллаж үзээгүй байх.
- Ажиллая гэвэл зөвшөөрдөг. Цар тахлын үед суралцаж байгаа болохоор тиймхэн байна. Ажиллаж чадах бол сууж болно. Багш нарын зүгээс үгүй гэсэн зүйл бол байхгүй.

Б.Гантулга: Гар хуруугаа гэмтээсэн хүүхэд байна уу?

- Анх сурч байхдаа хуруугаа зурж байсан.
- Оюутны хөгжил хариуцсан мэргэжилтэн байдаг уу?
- Байдаг. Нэрийг нь санахгүй байна. Кабинет хариуцсан багш байдаг. Сургуулийн клубийг хариуцсан багш нар байдаг.

Багш нартай хийсэн цахим үүлзалтын товч тэмдэглэл

Б.Гантулга: Стратеги төлөвлөгөөндөө багшийг хөгжүүлэх ямар зорилт тавьсан бэ? Мэргэжил дээшлүүлэх төлөвлөлтийг хэрхэн хийж байна? Эрдэм шинжилгээний бүтээлийг хэрхэн дэмжиж байна вэ?

- Сүүлийн үед идэвхжиж байна. Багш нарын тавин хувиас илүү нь докторант байна. Хоёр багш хамгаалах гэж байна. Удирдлагаас багш болгонтой ярилцаад хамгаалах төлөвлөгөөг нь сонсоод, зургаан сар хүртэлх цалинтай чөлөө олгох дэмжлэг үзүүлсэн.
- Эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл хэвлүүлэх нь байнгын ажил болоод байна. Багшийг хөгжүүлэх зардал гэж байдаг. Гадаадад өгүүлэл хэвлүүлбэл тэндээс даана. Японд хамгаалсан Наранцогт багш инфакт фактор өндөртэй сэтгүүлд өгүүллээ хэвлүүлэхэд нНайм болон нэгдүгээр сард сургуулиас багш нарт сургалт явуулдаг.

- Гадаадад мэргэшил дээшлүүлэх тал дээр хүсэл бий. Энэ тал дээр хангалттай сайн биш байна.
- Удирдлагад энэ талаар хүсэлт тавьсан уу?
- Захирлын тайлангийн хурал болдог. Тэрэндээр саналаа хэлдэг. Санхүүгийн хүндрэлтэй холбоотой тайлбарладаг. Нас, мэргэжил заахаар гадаад хэлгүй багш нар таарах юм.
- Нээлттэй боловсролын төв маань 9-12 сар хүртэл нээлттэйгээр МҮҮК-ийн хичээл өгсөн. Багш нар сайн хамрагдсан.
- Стратеги төлөвлөгөөг эхлээд багш, дараа нь тэнхим салбар төлөвлөөд явдаг болохоор бидний санал тусгагддаг.
- Багшийг эрдэм шинжилгээний хурал, өгүүлэл бичихэд анхаардаг. А- хичээл заах, Б- эрдэм шинжилгээний ажил, В- олон нийтийн ажил. Б цагт инфакт пактор өндөртэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх орно.
- Номын санд томоохон сэтгүүлүүдийн эрхийг авч өгсөн.
- Аливаа төлөвлөлт багшаас хамаардаг. Багш нар гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлбэл боломж нээлттэй. Би Шанхайд 21 хоногийн сургалтад хамрагдаад ирсэн. Үйлдвэрчний эвлэлээс хэл сурахад залуу багш нарт хөнгөлөлт үзүүлдэг.

Г.Одпүрэв: Сургуулийн зүгээс хөтөлбөрийн бодлогын бичиг баримтыг баталсан уу?

- Манайх ШУТИС2030 гаргасан. Баталсан. Хөтөлбөрийн дэд хороонд саналаа өгч болно.
- Таван сургуультай хөтөлбөрөө харьцуулжээ. Ямар арга замаар судалгаа хийсэн бэ (францын сургуулийн тухайд хөтөлбөр нь зөрүүтэй байна)?
- Сургалтын хөтөлбөрөө шинэчлэх явцдаа харьцуулсан. Таны харсан нь 2021 оны апдэйт хийсэн шинэ нь байх.
- IF өндөртэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх асуудал тулгамдаж байгаа. Энэ бол байгалийн шинжлэх ухааны чиглэлд бол амархан. Үүнийг өөрөөр орлуулах төлөвлөгөө байна уу?
- Б цагт эрдэм шинжилгээний ажил тооцож байгаа. ШУТИС гэдгээр нь нийтэд нь гаргачихдаг. Жил бүр бид хүсэлт гаргадаг. Уран бүтээлийг нь ЭШ-д тооцох гэсэн хүсэлт гаргадаг.
- Сүүлийн таван жилд гадаадад мэргэжил дээшлүүлсэн багш нар байна уу?
- Нарантогтох 1000 инженерээр японд хамрагдсан.
- Буяндэлгэр Шанхайд сургалтад хамрагдсан.
- Гэрэлмаа ӨМӨЗО-нд үзэсгэлэн гаргасан.
- Хөтөлбөрийн арга зүйг тодорхойлохдоо CDIO-г ашиглаж байна. Өөрт тохирсон шинэ арга зүйг боловсруулсан уу?
- Бүх багш нар CDIO сургалтад хамрагдсан. Сургалтууд маань энэ хэлбэрээр явдаг. Сурган, заах арга зүйн сургалт орсон. Үнэлгээний арга зүйгээ тодорхой болгосон. Оюутанд үлдэцтэй байх талаар арга зүй ашиглаж байна.
- CAD, CAM-ийн систем дутагдалтай яваад байгаа. Манайд шимазики азийн сургалтын төв байгаа. Оюутнууд тэр бүр хамрагдаж чадахгүй байна. Өнгөрсөн семистрээс ганц нэг оюутнуудаа оруулсан.
- CDIO бидэнд арга зүйн хувьд сэдэл өгсөн. Боломжтой үедээ долоо хоног бүр багааооа ярилцлага хийдэг байсан. Цаг төлөвлөлтийн тал дээр сургалтын арга зүй дээр анхаарах хэрэгтэй юм байна гээд тусгаж өгч байна.

Д.Тунгалаг: Та нарын төгсгөсөн бүтээгдэхүүн ажил олгогчдод хүрч байгаагийн хувьд тэдэнтэй хэрхэн хамтардаг вэ? Судалгаа хийдэг үү? Хамтарч ажиллах ямар боломжуудыг ашиглаж байна вэ?

- Манай хөтөлбөр анх элсэлт авснаасаа хойш ажил олгогчдын саналыг авч ирсэн. Дөрвөн жил тутам шинэчлэл хийгээд байна. Дадлага хийж бйагаа үед нь удирдагч багш нь ажил олгогчидтой уулзаад санал асуулга авч, санал солилцдог. Хичээлийн агуулгаа жил бүр дүн шинжилгээ хийж сайжруулдаг.
- Торгон зам, Урлахуйн ертөнц наадмууд жил бүр болдог. Энэ нь ажил олгогчидтой холбогдох сэжм юм. Тэд өөрсдийн нэрэмжит шагналаа өгдөг, саналаа хэлдэг.
- Ажил олгогчид маань дипломын ажил дээр суудаг. Саналаа хэлдэг. Сайн оюутнуудыг ажилд урьдаг.

Б.Гантулга: Бүх хичээлүүд CDIO-д шилжсэн үү? Энэ хөтөлбөрийн хичээлүүдийн үнэлгээг яаж хийж байна? Гадаадад докторантурт суралцаж байгаа багш байна уу?

- CDIO хэлбэрт тэнхимээс зааж байгаа бүх хичээлүүд орсон. Мэргэжлийн, мэргэшүүлэх бүх хичээлүүд орсон. Мэргэжлийн зохиомжийн хичээл дээр үзэсгэлэн гаргаад комисс дүгнэдэг. Covid 19-ийн үед face to face teams-ээр явж байна.
- Би 1997 оноос хойш багшилж байна. Өнөөгийн хөтөлбөртөө сэтгэл хангалуун байна. Шинэчлэгдэж байна.

Д.Тунгалаг: Дизайны хичээлүүд орж байгаа юу?

- Нэхмэлийн дизайн гэж мэргэжил байсан. 2014 онд нэгтгэ, багасга гэсээр хүчээр нэгтгэсэн. Тэр хөтөлбөрийн шинэчилсэн хувилбарыг манай хөтөлбөр давхар авч явна. Текстил, сүлжмэлийн дизайн орж ирсэн. Сүлжмэлийн гурван хичээл байна. Текстил дизайн хичээлд бусад хичээлүүдийн агуулга багтаж орсон. Онцлогтой явж байгаа хөтөлбөр.
- Сүлжмэлийн хичээлүүд заавал судлахад гурав, сонгон судлахад бас байгаа. Зарим оюутнууд санал гаргаад сүлжмэлийн үйлдвэрт дадлага хийж байна.
- Манай хөтөлбөрөөс гадаадад сурч байгаа багш байхгүй.
- Бид нар бүтээл дээр суурилдаг болохоор Microsoft teams их давуу талтай. Боломжийн гэж үнэлж байна.
- Бид нар 2014 онд хөтөлбөрөө шинэчилж байхдаа хичээлийн уялдаа холбоог мод байдлаар гаргаж байсан. Анхнаасаа төлөвлөж хийсэн.

Г.Одпүрэв: CDIO өөрөө инженерийн боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд зориулсан. ШУТИС сонгодог загвараар хэрэгжүүлж байна. Та бүхэн тэр чигээр нь хэрэгжүүлж байна уу, өөрийн онцлогт тохируулан хэрэглэж байна уу?

- Хувцасны дизайн хөтөлбөр тэр чигээрээ CDIO. Загвараа гаргаад, туршаад, хүнд өмсүүлээд, засаад явдаг. Багцаараа анхны зургаасаа авахуулаад бэлэн бүтээгдэхүүн гартлаа CDIO загвараар явдаг.

Б.Гантулга: Зохиомжийн үзлэг явагдах уу?

- Бидний сургалтад үзэсгэлэнгийн загвараа хадгалж байгаа. Баг томилоод үздэг. Харьцангуй цөөн хүнтэй баг. Саяны улирлын тал нь танхимаар орсон учир ямар нэг асуудалгүй, хэвийн, оюутнууд түвшиндээ явж байгаа гэж үзэж байна.
- Тиймс программыг ашигласнаар багш оюутны ажлыг үзээд комент үлдээгээд, тэрний дагуу оюутан ажиллана. Хистори дээр хэдэн удаа тухайн оюутантай харилцсан нь харагддаг.
- Бид өөрсдөөсөө хамаарах зүйлээ хийж байна. Хамгийн хэцүү нь байр талбайн асуудал байна. Одоогийн байрыг акталсан. Орчны асуудал тиймхэн байна. Шинэ байрны зураг төслийг нь гаргасан. Хүлээлтийн байдалтай байна. Цаашдаа шинэ байранд орвол үзэсгэлэн, просматын асуудал шийдэгдэнэ.
- Оёдлын, исгүүрийн, индүүдлэгийн, хатгамалын машинуудтай болсон. Энэ нь оюутнуудад урам өгч байна.

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН**  
**СУРГУУЛЬ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 34, 8 дугаар хороо, ШУТИС-ийн I байр,  
Утас/Факс: (976-11) 31 19 07, И-мэйл: sit@must.edu.mn,  
Вэбсайт: www.sitech.edu.mn

2021.03.04 № 028  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН**  
**ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

БМИҮЗ-өөс 2021 оны 01 дүгээр сарын 22-нд D021201 индекстэй “Хувцасны дизайн” хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчдийн нэгдсэн тайланг хүлээн авч таниллаа.

БМИҮЗ-ийн шинжээчдийн тус хөтөлбөрт өгсөн дүгнэлт, нэгдсэн үнэлгээг хүлээн зөвшөөрч байна.

Та бүхний цаашдын ажил үйлсэд амжилт хүсье.

ЗАХИРАЛ



Ж.ТУЯАЦЭЦЭГ

367760406



#### ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2021.03.22  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

| Магадлан итгэмжлэх эсэх | Магадлан итгэмжлэл олгох хугацаа |
|-------------------------|----------------------------------|
|                         |                                  |

**Зөвлөмж /Recommendations/**

#### ҮІІ. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

| Магадлан итгэмжлэх эсэх | Магадлан итгэмжлэл олгох хугацаа |
|-------------------------|----------------------------------|
|                         |                                  |

**Зөвлөмж /Recommendations/**